

ШУА-ИЙН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ АКАДЕМИЧ Т.ДОРЖИЙН ХЭЛСЭН ҮГ

Эрхэм хүндэт Элчин сайд Ван Сяолун,

Хүндэт ноёд, хатагтай нараа,

Өнөөдөр ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас хамтран “БНХАУ дахь шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлт: Монгол-Хятадын харилцааг хөгжүүлэх шинэ боломж” эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж байна. Манай хоёр орон бие биеийнхээ нийгэм улс төр, эдийн засгийн амьдралд гарч буй өөрчлөлт шинэтгэлийн үйл явцыг тал бүрээс нь анхааралтай судлах явдал бол хоёр орны харилцааг цаашид гүнзгийрүүлэхэд нэн чухал ач холбогдолтой. Энэ утгаараа манай их хөрш БНХАУ-д 1978 оноос эхэлсэн шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлт нь Монгол Улсын гадаад орчинд шууд нөлөөлж байдаг чухал үйл явц юм. Өөрөөр хэлбэл манай улсын хөгжил дэвшил, гадаад худалдаа, төсвийн орлого Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн харилцааны төлөв байдал, түүний дотор Хятад улсын макро эдийн засаг, зах зээлээс нэлээд хэмжээгээр хамааралтай явж ирлээ. Цаашид ч энэ байдал хэвээр үргэлжилнэ. Иймд Хятадын шинэтгэл, нээлттэй бодлогыг манай эрдэмтэд, ялангуяа ШУА-ийн зүгээс урьд өмнөхөөс илүү далайцтай гүн гүнзгий судалбал зохино хэмээн эдийн засагч хүний хувьд миний бие бодож явдаг.

БНХАУ дахь шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлтийн онцлог бол зах зээл рүү улам эрчимтэй ороход чиглэгдэж байгаа бөгөөд энэ нь хоёр орны харилцааг харилцан ашигтай байж тал бүрээр улам эрчимжүүлэн, шинэ шатанд гаргах шинэ боломж нээж өгч байна.

Саяхан манай хоёр орны ерөнхий сайд нар Бээжинд гарын үсэг зурсан “Монгол-Хятадын стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх дунд болон урт хугацааны хөтөлбөр” нь Монгол-Хятадын стратегийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чухал үндэс суурь юм. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх

асуудал хоёр орны холбогдох байгууллагууд бүхий л түвшинд хэлэлцэж байгаа чухал цаг үед та бүхний энэхүү хурлыг зохион байгуулж буй нь үнэхээр цагаа олсон байна гэдгийг онцлон тэмдэглэмээр байна.

Тус бага хуралд Хятадын нэрт улс төрийн зүтгэлтэн, эрдэмтэн БНХАУ-ын Ардын Их Сургуулийн Хэвлэл мэдээллийн сургуулийн захирал, Нанькай Их Сургуулийн Биньхай хөгжлийн судалгааны хүрээлэнгийн захирал Жао Цижэн уригдан оролцож "БНХАУ-ын шинэчлэл өөрчлөлтийн шинэ үе" сэдвээр үндсэн илтгэлийг тавьж байгаа нь тус хурлын эрдэм шинжилгээний ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна. Ийнхүү тус бага хурлын сэдвийн агуулга, ач холбогдлыг авч үзсэн ч мөн Монгол, Хятадын нэртэй эрдэмтэд, улс төрчид, бизнесменүүд уригдан оролцож байгаа нь ч энэхүү хурал ихээхэн амжилттай, үр дүнтэй болно гэдэгт итгэлтэй байна.

Тус хуралд амжилт хүсье.